



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 113

Баянхутаг сум

┌ Эзэмшил газрын талбай хэмжээ, ┐
байршил өөрчлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 20.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57 –д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд дурьдсан 2 хоршоонд 50000 м2 газрыг мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2. Захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2024 оны А/94 тоот захирамжийн холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгож гэрээг байгуулан, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамлын түр орлон гүйцэтгэгч /Т.Наранбаяр/-т, гэрээнд заасан зориулалт, нөхцлийг хангаж ажиллан, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч малчдын хоршоонд үүрэг болгосугай

ДАРГА

Б.АМГАЛАНБАТ



Сумын Засаг даргын 2024 оны ᠘᠙ дугаар
сарын ᠒᠙ өдрийн ᠒᠙᠘ тоот захирамжийн
᠒᠙ тоот хавсралт



№	Газар эзэмшигчийн		Өмнөх захирамжийн				Өмнөх газрын		Одоо	
	Оноосон нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн	Хэмжээ /м2/	Хаяг	Хэмжээ /м2/	Хаяг
1	Өнө Дэлгэрэх рашаант	4212509	2024/10/01	А/94	1	2	50000	Хаялагат	20000	Хаялагат Хэрлэн зоогийн зүүн талд
2	Баян хайрхан дэнж	4191927	2024/10/01	А/94	1	3	50000	Хаялагат	30000	Хаялагат хангарьд колонкын замын урд
							100000		50000	